



**ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 09/25.

Жаргалант сум

“Жаргалантын ногоочид” хөтөлбөр болон  
хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгүүдийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Жаргалантын ногоочид” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Засаг дарга (Л.Учрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны  
09/25 тогтоолын нэгдүгээр хавсралт

**“ЖАРГАЛАНТЫН НОГООЧИД”  
ХӨТӨЛБӨР**

**НЭГ.ТӨМС ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Жаргалант суманд үр тариа болон төмс хүнсний ногоо тариалдаг 10 ААНБ төмс, хүнсний ногоо тариалдаг 265 өрх төмс хүнсний ногоо тариалж байна. Үүнд:

Д/Д	Таримлын нэр	2022				2023				2024			
		Тариалсан талбай/га/	Хураасан талбай /га/	Нэгжийн ургац цн/га	Авсан ургац /тн/	Тариалсан талбай/га/	Хураасан талбай /га/	Нэгжийн ургац цн/га	Авсан ургац /тн/	Тариалсан талбай/га/	Хураасан талбай /га/	Нэгжийн ургац цн/га	Авсан ургац /тн/
1	Төмс	119	119	109,4	1302	106	106	106,4	1128,1	111,3	111,3	116,4	1296
2	Хүнсний ногоо	395,6	395,6	150,8	5968	388,8	388,8	223,4	8685,3	390,5	390,5	270,4	10531
3	Үүнээс: Хүлэмж	2,34	2,31	750,6	173,4	2,2	2,2	1217,7	267,9	2,5	2,5	1148	287

2019-2020 онд “Жаргалантын ногоочид” богино хугацааны дэд хөтөлбөр, 2021-2024 онд “Жаргалантын ногоочид” дунд хугацааны хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж өрхийн тариаланчдын мэдлэг, чадварыг сайжруулах, хөдөлмөрийг механикжуулах, шинэ техник технологи нэвтрүүлэх, зоорийн аж ахуйг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн боловч хүрэлцээ муутай байна.

**ХОЁР.ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ**

**2.1.**Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43-р тогтоолоор батлагдсан Ногоон хөгжлийн бодлого, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52-р тогтоолоор батлагдсан Алсын хараа 2050 Урт хугацааны хөгжлийн болого, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны 476 дугаар тогтоолоор батлагдсан Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх

**2.2.**Орхон аймгийн иргэдийг хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан сайн чанарын төмс, хүнсний ногоогоор хангахад төмс хүнсний ногоо тариалагч иргэд, ААН-д орон нутгийн онцлогт тохирсон, чанарын шаардлага хангасан төмс, хүнсний ногооны үрийн хангамжид дэмжлэг үзүүлэх, техник, технологийг шинэчлэлийг нэвтрүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах арга замаар нэгжийн ургацыг нэмэгдүүлэх нь зайлшгүй хэрэгцээ болоод байна. Ногоочдыг хоршоо, бүлгийн зохион байгуулалтад оруулж цаашдын үйл ажиллагаанд шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд орон нутгийн зүгээс бодлогоор дэмжиж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай .

**ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

“Жаргалантын ногоочид” хөтөлбөрийг батлуулж, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянахад удирдлага зохион байгуулалтын дараах зарчмыг баримтлана.

3.1.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих төсөл, үйл ажиллагааг тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсэг хариуцна.

3.2.Газар тариалангийн үйлдвэрлэлд техник, технологийн дэвшил, шинжлэх ухааны ололтыг ашиглах

3.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг чухалчлах

3.4.Хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөг сумын иргэд Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлж, тайлагнана.

### ДӨРӨВ.ЗОРИЛГО

Төмс хүнсний ногоо тариалагч өрхийн тариаланчдын мэдлэг, чадварыг сайжруулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх, шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хүлэмж, зоорины аж ахуйг дэмжих замаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хүн амыг төмс, хүнсний ногоогоор жигд тогтвортой хангах.

### ТАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ДОР ДУРДСАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

5.1.Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулах, дэвшилтэт техник, технолги нэвтрүүлэх, усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах замаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх

5.2.Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжих, таримлын нэр төрлийг олшруулах, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих

5.3.Төмс, хүнсний ногооны үрийн чанарыг сайжруулах, хангамжийг нэмэгдүүлэх

5.4.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчид болон техник дундын үйлчилгээ эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.

### ЗУРГАА.ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

“Жаргалантын ногоочид” хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

### ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН SWOT ШИНЖИЛГЭЭ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"><li>Сумын нийт өрхийн 25 % орчим нь өрхийн тариалан эрхэлдэг.</li><li>Газар тариалан эрхлэхэд харьцангуй таатай байгаль, цаг уурын нөхцөлтэй.</li><li>Том зах зээлд ойр, дэд бүтэц сайн хөгжсөн.</li><li>Хөтөлбөрийн өмнөх шатанд техник тоног төхөөрөмжийн хангамж сайжирсан</li><li>Мэргэжлийн бөгөөд тодорхой туршлагатай тракторын жолоочтой</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорийн хангамж муу.</li><li>Сэлэнгэ, болон Булган аймгийн ижил үйл ажиллагаа явуулдаг өрсөлдөгч олонтой.</li><li>Иргэдийн эзэмшиж буй талбайн хэмжээ бага учир ээлжлэн тариалах боломж муу. Хортон шавьж, өвчлөл нэмэгдэх хандлагатай</li><li>Техник тоног төхөөрөмжийн хангамж өмнөх оноос сайжирсан боловч хүрэлцээ муу</li></ul>
БОЛОМЖ	АЮУЛ
<ul style="list-style-type: none"><li>Таримлын төрлийг нэмэгдүүлэх</li><li>Хамгаалагдсан хөрсний тариалалт нэмэгдүүлэх</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Цаг агаарын дулаарлаас хамаарч хөрсний өнгөний болон гүний ус татарч байна.</li></ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Төрөлжсөн зоорийн багтаамж нэмэгдүүлэх</li> <li>• Өртөг шингэсэн эцсийн бүтээгдхүүн үйлдвэрлэх</li> <li>• Өрхийн орлогоо нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртсоноор хөрс элэгдэл, эвдрэлд орох нөхцөл бүрдсэн</li> <li>• Ган зудын давтамж ойртож, хур тунадасны хэмжээ багасч, оройтох болсон</li> </ul>
--	---

## **НАЙМ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ДАРААХЬ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ**

### **8.1.1-р зорилтын хүрээнд**

- 1.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдэд нэн шаардлагатай байгаа чиргүүл, дүүжин машин, усалгааны тоног төхөөрөмж, гар багажийг шат дараатай худалдан авах.
- 2.Хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургацын чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор органик болон эрдэс бордоог хэрэглэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх.
- 3.Төмс хүнсний ногооны талбайн усалгааны системийг инженерийн хийцтэй болгох

### **8.2.2-р зорилтын хүрээнд**

- 1.Өвлийн болон 3 улирлын хүлэмжийн аж ахуйг байгуулахад дэмжлэг үзүүлэх.
- 2.Өрхийн тариаланчдыг зуны нийлэг хальсан хүлэмж байгуулахад зориулж хөнгөлттэй нөхцөлөөр дэмжлэг үзүүлж таримлын нэр төрлийг олшруулах.
- 3.Зоорийн багтаамжийг нэмэгдүүлэх, сэргээн засварлахад төр хувийн хэшлийн хамтын ажиллагааг ханган ажиллах

### **8.3.3-р зорилтын хүрээнд**

Төмс, хүнсний ногооны гарал үүсэл нь тодорхой чанарын баталгаатай элит, сортын болон эрлийз үр үйлдвэрлэх, борлуулах ААН, иргэнийг дэмжих

### **8.4.4-р зорилтын хүрээнд**

- 1.Орон нутгийн болон бусад аймаг сумдын тэргүүний арга ажиллагаатай өрхийн тариаланчдын хүлэмжийн ашиглалт, усалгааны шинэ техник, зоорийн тоног төхөөрөмжтэй танилцуулах, харилцан туршлага судлуулах, сургаж дадлагажуулах замаар төмс, хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийн шинэ технологийн мэдлэгийг дээшлүүлэх.
- 2.Төмс, хүнсний ногоо тариалах, арчлах, ургацыг хадгалах, боловсруулах технологи, арга ажиллагааны талаар сургалт зохион байгуулах.
- 3.Техник дундын үйлчилгээ эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургах, туршлага судлуулах

## **ЕС.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ**

**9.1** Орон нутгийн төсвөөс

**9.2** Иргэдийн өөрийн хөрөнгө

**9.3** Хоршоо хөгжүүлэх сан

**9.4** Бусад эх үүсвэр

## **АРАВ.ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**

**10.1** .Үйл ажиллагааг хөнгөвчилсөн дэвшилтэд технологийн тоног төхөөрөмжийн хангамж нэмэгдсэн байна.

**10.2** .Төмс, хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээ, нэгжийн ургац тогтворжиж, нэмэгдсэн байна.

**10.3** .Чанарын шаардалга хангасан төмс, хүнсний ногооны үрийн хангамж сайжирсан байна.

**10.4** .Усалгаатай тариалангийн талбай нэмэгдсэн байна.

**10.5** .Хамгаалагдсан хөрсний талбай нэмэгдсэн байна.

**10.6** .Өвлийн болон 3 улирлын хүлэмжийн ашиглалт болон талбайн хэмжээ нэмэгдсэн байна.

**10.7** .Зориулалтын агуулах, зоорьны тоо, багтаамж нэмэгдэнэ.

**10.8** .Тракторын жолоочийн ур чадвар өсч, технологит ажлын чанар сайжран, техникийн эвдрэл

гэмтэл багасч хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн байна.

### 11.ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

11.1.Хэрэгжилтийг холбогдох төр захиргааны болон хувийн байгууллага, ард иргэдтэй хамтран хэрэгжүүлж үр дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд жил бүрийн IV улиралд багтаан танилцуулна.

11.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин 2028	
1	Агроүйлчилгээний төвийн техникээр үйлчлүүлэгчдийн тоо	ш	403 ААН, иргэн 526 га	10 %-иар өсгөнө	
2	Нэгж талбайн ургац	төмс х/ногоо хүлэмж	цн/га	108,9	120
				215	250
				1138	1250
3	Хүнсний ногооны үр нийлүүлэх цэг	ш	1	Хүнсний ногооны үр нийлүүлэх цэгийг тогтвортой ажиллуулах нөхцлөөр хангана. Төмсний үр үржүүлэх ААН-1	
4	Хамгаалагдсан хөрсний хэмжээ	га	2,53	2,8	
5	Өвлийн болон гурван улирлын хүлэмж	га	0,115	0,13	
6	Усалгаатай талбайн хэмжээ, болон усалгааны нөхцөлийг сайжруулах	га	80,8	100 га	
7	Сургалтанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	тоо	65	200	
8	Төмс хүнсний ногооны шинээр барьсан болон засч сайжруулсан зоорины багтаамж	тн	100	160 тн-оос багагүй хэмжээгээр нэмэгдсэн байна	

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны  
42/15. тогтоолын хоёрдугаар хавсралт



**"ЖАРГАЛАНТЫН НОГООЧИД" ХӨТӨЛБӨРИЙГ 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/Д	Хөтөлбөрт тусгагдсан зорилт	Бодлого төлөвлөлтөний уялдаа	Зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Шардлага хэмжээ /ш/	Эх үүсвэр	Суурь түвшин /2024 он/	Хүрэх түвшин, үр дүн, төсөв 2025он		Хэрэгжүүлэх байгууллага		
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв /сая.төг /	Үндсэн	Үндсэн	Хамтрагч
<b>Зорилт 1. Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, , усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах замаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх</b>												
1	1.1.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдэд нэн шаардлагат ай байгаа чиргүүл, дүүжин машин, усалгааны тоног төхөөрөмж, гар багажийг дараатай худалдан авах	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын Засаг даргын 2024-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Хөрс бутлагч	Тоо хэмжээ	1	ОНХС	1	2	14,0	ЗДТГ	ААН, байгууллагууд	Иргэд
2			Анжис	Тоо хэмжээ	1	ОНХС	2	3	15,0	ЗДТГ	ААН, байгууллагууд	Иргэд
3			Зиг заг борной	Тоо хэмжээ	1	ОНХС	2	5 болж 3 агрегат иргэдэд үйлчилнэ	2,1	ЗДТГ	ААН, байгууллагууд	Иргэд
4			Үрсэлгээ суулгагч	Тоо хэмжээ	1	ОНХС	1	2	32,0	ЗДТГ	ААН, байгууллагууд	Иргэд
5			Өвс тэжээл хаман боогч	Тоо хэмжээ	1	ОНХС	3	4 агрегат ажиллана	80,0	ЗДТГ	ААН, байгууллагууд	Иргэд
6			2024 онд гэрээгээр худалдан	Төлбөрийн хэмжээ	87,347	ОНХС	29.865	117.212	87.347	ЗДТГ	ААН, байгууллагууд	Иргэд



11	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагаа-ны хөтөлбөр	Зорь шинээр барих болон засварлах иргэдэд хэрэглээний модны эрхийн бичгийг шийдвэрлүүлэх талар олгосон Хэрэг-лээний модны хэмжээ	Бусад	2 иргэнд 25 м3 хэрэглээний модны эрхийн бичиг олгосон.	Иргэдийн санаачилгыг дэмжин ажиллана	Иргэд
12	Төмс хүнсний ногооны зоорийн багтаамжийг жил тутам 40тн-оос багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх	Шинээр болон засварл асан зоорийн багтаамж	Бусад	2 иргэн 100 тн багтаамжтай зоорь барьсан	Иргэдийн санаачилгыг дэмжиж 40 тн-оос багагүй энгийн зоорь барина	Иргэд
<b>3-р зорилт: Төмс, хүнсний ногооны үрийн чанарыг сайжруулах, хангамжийг нэмэгдүүлэх</b>						
13	3.1.Төмс, хүнсний ногооны гарал үүсэл нь тодорхой чанарын баталгаатай элит, сортын болон эрлийз үр үйлдвэрлэх,	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, Орхон аймгийн Засаг даргын 2025-2028	Бусад	Манай сумын дийлэнх үрийг Монгол ногоо төслийн үрийн дэлгүүр хангадаг	Үр нийлүүлэх суваг нэгээр нэмэгдэнэ	Иргэд, ААН, байгууллагууд

борлуулах ААН, иргэнийг дэмжих	оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Төмс, хүнсний ногооны үр сортын шинэчлэл	Шинэ үр сортын хэмжээ	ОНХС	-	Ургац өндөр шинэ сортын үрийн хангамж сайжирна	80,0	ЗДТГ	ААН, байгууллаг ууд	Иргэд
--------------------------------	---	--	-----------------------	------	---	--	------	------	---------------------	-------

**4-р зорилт : Өрхийн тариаланчдыг тэргүүний ажиллагаатай ААН, тариаланчдын услалтын систем, тоног төхөөрөмжийн ашиглалт, зоорины тоног төхөөрөмжийн талаар туршлага судлах, сургаж дамгажуулах замаар төмс, хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийн шинэ технологийн мэдлэгийг дээшлүүлэх.**

14	4.2.Мэргэжлийн сургалтын байгууллага болон сургагч багш нартай хамтран ажиллаж, өрхийн тариаланчдыг сургалтад хамруулах	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Агроүйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулах танхимын болон талбайн сургалт	Сургалтын тоо/ хамрагдсан иргэний тоо	1-ээс баггүй	Бусад	Усны менежмент, усалгааны арга, техник базоорин хийц сургалт танхимын хэлбэрээр зохион байгуулж 33 өрхийн тариаланч хамрагдсан.	Үйлчилгээний чанар дээшилнэ	-	ЗДТГ	Багш, иргэд, ААН, байгууллаг ууд	Иргэд
----	---	--	--	---------------------------------------	--------------	-------	---	-----------------------------	---	------	----------------------------------	-------

15	Төмс хүнсний ногооны талбайг өргөтгөж, тариалалтыг төрөлжүүлэн, үйлдвэрлэлийн аргаар хүний хөдөлмөрийг хөнгөвчилсэн, техник технологийг нэвтрүүлэх судалгааны ажил	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.2.2	Судалгаа	Судалгаанд хамрагдсан өрхийн тариалагчдын тоо	%	Бусад	-	80%-иас багагүй хамруулна	20.0	ЗДТГ	Багийн ажлын албад	Иргэд
											592,587	
											ОНХС	
											Бусад	
											20,000,00	

---000---